

# SEALIT UNIVERSAL ӨРГӨН ХҮРЭЭНИЙ ХАВТАН

## ХООРОНДЫН ЗАВСРЫН ЧИГЖЭЭС

### ТОДОРХОЙЛОЛТ



SEALIT UNIVERSAL мэргэжлийн чигжээс нь бетон, тоосгон барилгын фасад, металл, цагаан тугалга болон цайрдсан гадаргуу, гипсэн хананы хавтан, мод, PVC материалын завсар болон заагыг битүүмжлэхэд зориулагдсан. Чигжээс нь зөвхөн гадна ажилд зориулагдаагүй бөгөөд цонхны хүрээг суурилуулахад дотор давхаргын зориулалтаар өргөн

хэрэглэгддэг. Уур нэвтрүүлдэггүй өндөр чанар нь орчны чийгшлийн тав тухтай түвшинг хангадаг.

### ШИНЖ ЧАНАР

- Уур нэвтрүүлдэггүй шинж чанар өндөр.
- Хагарал болон заагыг найдвартай битүүмжилдэг. Ус, салхи, тоос шороог нэвтрүүлдэггүй.
- Цаг агаарын нөлөө, салхи, нар, бороо болон температурын өөрчлөлтөнд тэсвэртэй.
- Өтгөн бүтэц нь чигжээсийг хэвтээ болон налуу гадаргууд түрхэх боломжийг өгдөг.
- Завсрыг полимержсэний дараа чигжээсийг хэрэгтэй өнгөөр будах болон дээр нь засал чимэглэл хийж болно.
- 15%-иас ихгүй деформацитай тасралтгүй завсар үүсгэдэг.
- Ашиглалтын хугацаа 10жилээс багагүй.

### ШИНЖ ЧАНАР

Уурнаас хамгаалах чанар өндөр. Гадаргууг будах боломжтой (зөвхөн уян харимхай усны тархалттай найрлагатай нийцтэй байдлыг урьдчилан шалгах хэрэгтэй), материалыг бөөнөөр нь будах боломжтой.  $-18^{\circ}\text{C}$  хүртэл бага температурт ажиллах боломжтой. Чийгтэй (нойтон биш) гадаргуу дээр хэрэглэж болно. Өндөр тиксотроп чанарын тусламжтай чигжээсийг нэмэх, хасах налалтын өнцөгтэй хэвтээ, босоо, налуу гадаргууд түрхэж болно. 15% деформацитай барилгын бүтцэд удаан эдэлгээтэй завсарын чигжээс үүсгэдэг.

## **ГАДАРГУУГ БЭЛТГЭХ**

Sealit Universal чигжээс нь шууд хэрэглэхэд бэлэн байдаг. Бага температурт чигжээсний зуурамтгай чанар нэмэгддэг, тиймээс хэрэглэхийн өмнө чигжээсийг халаалттай орчинд нэг хоногоос багагүй хугацаанд байлгахыг зөвлөж байна. Чигжээсийг усаар шингэлж болохгүй, энэ нь чигжээсний шинж чанарыг өөрчилж (наалдамхай чанар багасах, тиксотроп чанар алдагдах гэх мэт) болох ба хагарал үүсгэнэ.

Гадаргуугаас шороо, тоос, өөх тос, сул хэлтэрхий, цементний зуурмагийн үлдэгдэл, өмнө нь хэрэглэсэн битүүмжлэх материалын үлдэгдэл, нэвчилт, лак, шиллэгээний найрлага гэх мэт бохирдлыг цэвэрлэнэ. Гадаргуу дээр дуслын чийг байж болохгүй. Бороо болон цас орж байхад чигжээсийг түрхэж болохгүй. Агаарын чийгшил багатай халуун цаг агаарт гадаргуу нь чийгийг их хэмжээгээр шингээдэг ба чигжээс хүрсэн газартаа маш хурдан хатдаг. Чигжээс нь гадаргуу дээр барицалдаж амжилгүй түүн дээр хөндийрдөг. Ийм тохиолдолд гадаргууг шүршигчний тусламжтай усаар урьдчилж чийглэхийг зөвлөж байна.

## **ХЭРЭГЛЭХ ЗААВАР**

Чигжээсийг бэлдсэн гадаргуу дээр шпател, тусгай гар эсвэл хийн шахуургат бууны тусламжтай түрхэнэ. Хоосон зайтай эсвэл нягтралгүй байж болохгүй. Гадаргууд түрхсэн чигжээсэнд тусгай шаблону тусламжтай шаардлагатай хэлбэрийг өгдөг. Чигжээсийг багаж хэрэгсэлд наалдуулахгүйн тулд савантай ус хэрэглэнэ.

Чигжээсийг түрхэхдээ ирмэгийг бохирдуулахгүйн тулд наалдамхай лентээр хамгаалахыг зөвлөж байна. Температур буурж, чийгшил нэмэгдэхэд хатах хугацаа нь нэмэгдэнэ. Хасах температурт чигжээс нь удаан полимерждэг бөгөөд энэхүү сул талыг өөрчлөх боломжгүй, эс бөгөөс гэсэх болон хур тунадас нь бүрэн полимержоогүй завсрыг гэмтээж болно.

Хэрэглэх температурын хүрээ:  $-18^{\circ}\text{C}$ -ээс  $0^{\circ}\text{C}$  хүртэл,  $+5^{\circ}\text{C}$ -ээс  $+35^{\circ}\text{C}$  хүртэл.

Ашиглалтын температурын хүрээ:  $-40^{\circ}\text{C}$ -ээс  $+80^{\circ}\text{C}$  хүртэл.

**ХОРИГЛОНО!** Бороо болон цас орж байх үед чигжээсийг түрхэж болохгүй! Агаарын чийгшил багатай халуун цаг агаарт гадаргуу нь чийгийг их хэмжээгээр шингээдэг. Ийм тохиолдолд гадаргууг шүршигчний тусламжтай усаар урьдчилж чийглэхийг зөвлөж байна.

## **ХАТАХ ХУГАЦАА**

Гадаргуугын хальс үүсэх хугацаа 1цаг ( $+23^{\circ}\text{C}$  температурт, чийгшил 60%). Давхаргын зузаан 5мм байх үед хатуурах хугацаа 24цаг ( $+23^{\circ}\text{C}$  температурт, чийгшил 60%).

## **БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ**

Хатуураагүй тохиолдолд бүлээн усаар угаана. Хатуурсан тохиолдолд механик аргаар арилгана.

## ТЕХНИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бүтэц	Тиксотроп зуурмаг (урсдаггүй)
Суурь	Полиакрилат
Хатууралт	Агаарт хатдаг, усны ууршилт
Гадаргуугын хальс үүсэх хугацаа, цаг	1цаг (+23°C температурт, чийгшил хэвийн)
Давхаргын зузаан 5мм байх үед хатуурах хугацаа	4хоног (+23°C температурт, чийгшил хэвийн)*
Хуурай үлдэгдлийн норм, %, багагүй	72%
Уур эсэргүүцэх чадвар, м <sup>2</sup> *цаг*Па/мг, багагүй	2
Нягтрал, багагүй	1,50 кг/л
Санал болгох хэрэглээний температурын хүрээ	+5°C-ээс +35°C хүртэл, -18°C-ээс 0°C хүртэл (хүйтэн тэсвэртэй чигжээсний хувьд), үндсэн температурыг оруулаад
Ашиглалтын температурын хүрээ	-40°C-ээс +80°C хүртэл
Хагарлын үеийн харьцангуй суналт	300%-иас багагүй
Хагарлын үеийн хүч чадал	0,15 МПа багагүй
Өнгө	цагаан, саарал. Захиалгын дагуу шар тоосго, улаан тоосго, бор тоосгоны өнгө гаргадаг.

### ХАДГАЛАХ НӨХЦӨЛ БОЛОН ТЭЭВЭРЛЭЛТ

+5°C-ээс +35°C хүртэл температурт хадгалж, тээвэрлэнэ.

Хүйтэнд тэсвэртэй чигжээсийг -18°C хүртэл температурт 7цикл хүртэл (цикл нь 1хоноогоос ихгүй) хөлдөөж гэсгээж болно, эсвэл -18°C хүртэл температурт 7хоноогоос ихгүй хугацаагаар нэг удаа хөлдөөж болно.

+22°C хүртэл температурт нэмэлт халаалт хэрэглэлгүй гэсгээнэ.

Савалгааг нээгээгүй үед хадгалах хугацаа үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24сар.

### НАЙРЛАГА

Полимерын усан дисперс, хувиргагч нэмэлтүүд, пигмент, дүүргэгч.

### АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗААВАРЧИЛГАА

ГОСТ 12.1.007 стандартын дагуу хатаагүй болон хатсан чигжээс нь бага аюултай бодисын ангилалд хамаардаг. Чигжээс болон бүрэлдэхүүн хэсгүүд нь зөвхөн галд хийсэн тохиолдолд шатдаг, удаан шатдаг, тэсрэх аюулгүй материалд багтдаг. Чигжээсний бүрэлдэхүүн хэсгүүд нь арьсанд удаан хугацаагаар хүрэхэд дерматит үүсгэдэг учир ажиллахдаа арьсанд шууд хүргэхгүй байх хэрэгтэй (резинэн бээлийтэй ажиллах хэрэгтэй). Бүрэлдэхүүн нь арьсны хамгаалаагүй хэсэгт хүрсэн тохиолдолд эхлээд цагаан спиртээр, дараа нь савантай бүлээн усаар угаах хэрэгтэй.